



ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯНХУТАГ СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 09 сарын 02 өдөр

Дугаар 5/М

Баянхутаг

Г.Будыг ажилд авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2, 47 дугаар зүйлийн 47.1, 49.1, 49.2 дахь заалт, Засгийн газрын "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 2024 оны 128 дугаар тогтоолын 9 дүгээр хавсралт, 2019 оны 382 дугаар тогтоолын 1, 6 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам", "Төрийн үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Ганзоригын Будыг 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрөөс номын санчаар ажиллуулсугай.

2.Г.Будын албан тушаалын зэрэглэлийг ТҮСБ-3 буюу 1334000 (нэг сая гурван зуун гучин дөрвөн мянга) төгрөг, орон нутгийн нэмэгдлийг 40 хувиар тус тус тооцон бодож олгохыг нягтлан бодогч (Х.Энхцэцэг)-д зөвшөөрсүгэй.

3.Г.Будыг ажил хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.
Үүнд:

Комиссын дарга: Ц.Цэрэннадмид (ОНСТ ажилтан)
Гишүүд: Л.Мөнхцогт (Хөгжмийн багш)
Д.Ганганмөрөн (Үйлчлэгч)

4.Ажил хүлээлцэх акт үйлдэж, 2024 оны 09 дугаар сарын 15 -ны дотор байгууллагын даргад бичгээр танилцуулахыг ажлын хэсгийн ахлагчид, номын санчийн албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүргийн хүрээнд холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг ханган хэрэгжүүлж, төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг чанд мөрдөж ажиллахыг номын санч (Г.Буд)-д тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

С.МӨНХХЭРЛЭН

